

Аудитын тайлан

АГУУЛГА

ХУУДАС

**Нэмэлтмэдээлэл авахыг хүсвэл
доорх хаягаар харилцана уу:**

Захирал Б.Шатар
Утас: 89383852
Цахим хаяг: baldandorjshatar@yahoo.com

- Аудитын гэрчилгээ
- Менежментийн захидал
- Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Гэрээт аудитор Д.Оюунбат
Утас: 89585807
Цахим хаяг: oyuna200702@yahoo.com

Хаяг:
Дундговь аймаг Сайнцагаан сум 7 дугаар
баг

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	Error! Bookmark not defined.
2	Аудитын тайлан.....	2
2.1	Оршил.....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	4
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	Error! Bookmark not defined.
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .	
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12	Шилэн дансны мэдээлэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	19
3.1	<u>«management zurchil1»</u>	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн төсвийн захирагч П.Ганчимэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Тус төв нь 2017 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, гэрээт аудитор Д.Оюунбат хариуцаж хэрэгжүүлэв.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж–Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв" нь 2017 онд “Сумын иргэдэд нийгтийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх нэмэлт тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулсан “ЖИШИГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ” болох” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Тус байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараахь хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- НД-ын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв" нь салбарын онцлогийг тусгасан НБББББ-гүй байна.

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв" нь санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн тодорхойлсон уламжлалт болон хяналтын эрсдэлийн дагуу горим хэрэгжүүлэн тэдгээрийг ТАБ-СТА-АБ.1-АБ.8 маягтуудаар баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудалд аудитыг чиглүүлэн, аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ийн дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орлогын дүнд тухайн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагддаггүй орлого тооцогдох магадлалтай бөгөөд нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн бага байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 328,524.2 мянган төгрөгөөс 1% буюу 3,285.2 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлын түвшинд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж /ТАБ-СТА-В-1/ маягтаар баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 1%-иар тооцсон нь сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсантай холбоотой.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын төлөвлөлтөөр нийт 8 дансанд эрсдэлтэй гэж тооцож, горим, сорил хэрэгжүүлэх явцад 5 дансанд алдаа зөрчил илрээгүй тул нарийвчилсан горим сорил хийгдээгүй бөгөөд зөрчилтэй гэж үзсэн 3 дансанд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баталгаажуулав. /ТАБ-СТА-В.3.1-В.3.3/, /ТАБ-СТА-В.3.9/

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараахь байдлаар ангилав.

(мянган төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	3,259.2	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	191.6	
3	Албан шаардлага өгсөн		0	
4	Аудитын явцад залруулсан	5	15,113.3	
5	Залруулагдаагүй алдаа	0	0	
6	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
7	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	8	18,564.1	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг /ТАБ-СТА-В-4.3-4.4/ маягтад нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Хоёр ажилтанд 191.6 мянган төгрөгийн цалинг, ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгожээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 13-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон цалинг орон нутгийн орлогод төвлөрүүлэх акт бичих

2. Сахилгын шийтгэл ногдуулсан тушаалын дагуу олговол зохих цалинг 1,064.0 мянган төгрөгөөр бууруулан тайлагнажээ.

Энэ нь УСНББОУС-1, УСНББОУС-25, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах

3. Нийгмийн даатгалын тайланд хоёр ажилтны цалинг 2,051.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

4. Эрүүл мэндийн газрын балансаас баланст шилжүүлсэн компьютерийг 360.0 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4 14 дүгээр зүйлийн 14.4, 14 дүгээр зүйлийн 14.4.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах

5. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 11,738.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4, 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах

6. Нэмэлт дансаар дамжуулан орон нутгийн орлогод төвлөрүүлсэн түрээсийн орлогын 824.4 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах

7. ХХОАТ-ын өглөг 1,126.7 мянган төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах

8. Төлбөрт үйлчилгээний орлого 1,208.1 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч, эм, эмнэлгийн багаж хэрэгсэл болон нэг удаагийн тэтгэмж урамшуулалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47.1.5, 47.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

- 1.9.1.1. Хоёр ажилтанд 191.6 мянган төгрөгийн цалинг, ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох заавар"-ын 13-т заасныг тус тус зөрчсөн байна.

1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага байхгүй.

1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

1.9.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 18,564.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 15,113.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 191.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт бичиж, алдаа зөрчил арилгуулах 3,259.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татсан асуудал байхгүй байна.

1.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-д өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээний урсгал зардалд зориулан 318,232.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

		/мянган төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	318,232.0	317,309.8	-0.29%	-922.1
1.1	Урсгал зардал	318,232.0	317,309.8	-0.29%	-922.1
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	318,232.0	317,309.8	-0.29%	-922.1
2.1	Улсын төсвөөс санхүүжих	318,232.0	317,309.8	-0.29%	-922.1
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Шивээговь сумын " Эрүүл мэндийн төв " нь 2017 онд 318,232.0 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсан бөгөөд төсвөө 100% авч, үйл ажиллагааны зардалд 317,309.8 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлт 922.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Төсвийн хэмнэлт 922.1 мянган төгрөг нь тогтмол зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй бөгөөд бүлэг хооронд гүйлгэн зарцуулаагүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар урсгал үйл ажиллагааны санхүүжилт 318,232.0 мянга, нэмэлт санхүүжилтийн дансаар төлбөрт үйлчилгээний орлого 1,208.1 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 1,144,807.8 мянга, сахилгын суутгал 1,064.8 мянга, нийт 1,465,312,7 мянган төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 318,232.0 мянга, нэмэлт санхүүжилтийн дансаар төлбөрт үйлчилгээний орлого 1,208.1 мянга, нийт 319,440.1 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Тус байгууллагын оны эхний авлага 868.1 мянга, өглөг 14,619.8 мянга байсан ба оны эцэст авлага 33.1 мянга, өглөг 1,126.6 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Бараа материалын дансны 2017 оны эхний үлдэгдэл 8,774.2 мянган төгрөг байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 37,731.7 мянган

төгрөгөөр нэмэгдэж, 35,080.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 11,425.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 647,590.8 мянган төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 980.4 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 1,145,323.5 мянга, нийт 1,146,303.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,793,894.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Тус байгууллагад 2017 онд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар төлбөрт үйлчилгээний орлого 1,208.1 мянган төгрөгийн санхүүжилт авч эм болон тэтгэмж урамшуулалд зарцуулсан байна.

1.11 Шилэн дансны мэдээлэл

Шивээговь сумын " Эрүүл мэндийн төв" Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэстэй бөгөөд 20 нэр төрлийн мэдээллийг 149 удаа оруулахаас 14 мэдээллийг хугацаа хоцроож, 90.6% хэрэгжүүлсэн байна.

1.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хариуг хугацаанд нь ирүүлсэн бөгөөд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

1.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэлээ.

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2017 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хугацаа: 17.12.31

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	ДАНС
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,642,322.86	11,458,225.75	1
2	АВЛАГА	868,100.00	33,100.00	33
2	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	33,100.00	33100
3	Бусад авлага	868,100.00	-	335
3	Хувь хүмүүсээс авах авлага	868,100.00	-	3352
4	БАРАА МАТЕРИАЛ	8,774,222.86	11,425,125.75	35
4	Түүхий эд материал	5,613,208.79	6,289,489.28	351
5	Тусгай зориулалттай материал	1,166,025.00	1,166,025.00	35110
5	Эм боох материал	4,447,183.79	5,123,464.28	35130
6	Хангамжийн материал	3,161,014.07	5,135,636.47	354
6	Бичиг хэргийн материал	879,225.00	1,185,965.00	35410
7	Аж ахуйн материал	257,340.00	238,040.00	35420
7	Сэлбэг хэрэгсэл	481,700.00	481,700.00	35430
8	Түлш шатах тослох материал	50.00	10,000.00	35440
8	Хүнсний материал	124,199.07	607,431.47	35460
9	Бусад хангамжийн материал	1,418,500.00	2,612,500.00	35470
9	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	460,097,784.81	1,568,627,654.52	2
10	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	460,097,784.81	1,568,627,654.52	39
10	Биет хөрөнгө	460,097,784.81	1,568,627,654.52	392
11	Барилга, байгууламж	545,187,074.00	1,655,172,159.00	39201
11	Хуримтлагдсан элэгдэл	(121,806,637.75)	(141,656,844.02)	39202
12	Авто тээврийн хэрэгсэл	1,660,000.00	33,440,000.00	39203
12	Хуримтлагдсан элэгдэл	(1,412,667.26)	(6,243,333.37)	39204
13	Машин, тоног төхөөрөмж	91,551,997.30	96,090,810.30	39205
13	Хуримтлагдсан элэгдэл	(56,960,876.39)	(69,990,064.95)	39206
14	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,461,784.91	8,461,784.91	39207
14	Хуримтлагдсан элэгдэл	(6,582,890.00)	(6,646,857.35)	39208
15	Програм хангамж	730,000.00	730,000.00	39301

Говьсүмбэр аймгийн “Шивээговь сумын Эрүүл мэндийн төв”-ийн 2017 оны санхүүгийн тайлан

15	Хасагдуулга	(730,000.00)	(730,000.00)	39302
16	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	469,740,107.67	1,580,085,880.27	3
16	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	14,619,852.12	1,126,655.00	4
17	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,619,852.12	1,126,655.00	41
17	Өглөг	14,619,852.12	1,126,655.00	413
18	Ажиллагчидтай холбогдсон өглөг	6,989,266.12	1,126,655.00	4131
18	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,277,136.00	-	4132
19	Бусад өглөг	1,353,450.00	-	4136
19	Байгууллагад төлөх өглөг	1,353,450.00	-	41361
20	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	455,120,255.55	1,578,959,225.27	5
20	Засгийн газрын хувь оролцоо	455,120,255.55	1,578,959,225.27	51
21	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	246,102,032.00	246,102,032.00	511
21	Өмч: -Төрийн өмч	246,102,032.00	246,102,032.00	51101
22	Хуримтлагдсан үр дүн	28,019,229.22	1,151,858,198.94	512
22	Өмнөх үеийн үр дүн	28,019,229.22	28,019,229.22	51210
23	Тайлант үеийн үр дүн	-	1,123,838,969.72	51220
23	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	180,998,994.33	180,998,994.33	51300
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	469,740,107.67	1,580,085,880.27	6

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Хугацаа: 17.12.31

№	ИТЕМ_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ	ДАНС
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	276,926,600.00	1,465,312,744.00	1
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,000.00	1,147,080,744.00	12
3	Нийтлэг татварын бус орлого	50,000.00	7,095,659.00	120
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	50,000.00	6,030,888.00	120004
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	-	1200041
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,208,100.00	1200042
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	4,822,788.00	1200045
8	Бусад орлого	-	1,064,771.00	120009
9	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,139,985,085.00	123
10	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	-	1,139,985,085.00	123003
11	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	276,876,600.00	318,232,000.00	13
12	Улсын төвлөрсөн төсвөөс	28,079,100.00	318,232,000.00	1310
13	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	28,079,100.00	318,232,000.00	131001
14	Төсвийн захирагчдаас	248,797,500.00	-	1330
15	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	248,797,500.00	-	133001
16	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	326,844,479.48	341,473,774.28	2
17	УРСГАЛ ЗАРДАЛ	326,520,747.48	332,725,418.28	21
18	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,520,747.48	332,725,418.28	210
19	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	192,696,482.00	189,031,859.88	2101
20	Цалин	192,696,482.00	189,031,859.88	210101
21	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,672,572.00	19,262,677.00	2102
22	Тэтгэврийн даатгалын шимтгэл	19,672,572.00	19,262,677.00	210201
23	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,396,936.00	41,737,625.00	2103
24	Гэрэл цахилгааны зардал	4,632,976.00	4,081,868.00	210301
25	Түлш, халаалтын зардал	20,873,354.00	35,358,994.00	210302
26	Цэвэр, бохир усны зардал	4,890,606.00	2,296,763.00	210303
27	Хангамж, бараа материалын зардал	14,458,155.00	12,557,479.00	2104
28	Бичиг хэргийн материал	2,068,300.00	1,537,860.00	210401

Говьсүмбэр аймгийн "Шивээговь сумын Эрүүл мэндийн төв"-ийн 2017 оны санхүүгийн тайлан

29	Тээвэр, шатахууны зардал	10,462,850.00	9,399,154.00	210402
30	Шуудан холбоо интернетийн төлбөр	862,705.00	606,405.00	210403
31	Хог хаягдал устгах, цэвэрлэх	609,150.00	1,014,060.00	210405
32	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	455,150.00	-	210406
33	Нормативт зардал	24,000,255.28	24,761,734.11	2105
34	Эм	15,249,052.28	18,072,380.51	210501
35	Хоол	6,051,553.00	4,767,353.60	210502
36	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,699,650.00	1,922,000.00	210503
37	Эд хогшил, урсгал засварын зардал	1,244,150.00	962,400.00	2106
38	Багаж хэрэгсэл	373,300.00	194,100.00	210601
39	Урсгал засвар	870,850.00	768,300.00	210604
40	Томиллолт, зочны зардал	820,500.00	1,013,250.00	2107
41	Дотоод томилолтын зардал	820,500.00	1,013,250.00	210702
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,281,495.00	1,270,300.00	2108
43	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,120,000.00	720,000.00	210802
44	Даатгалын үйлчилгээний төлбөр	81,675.00	285,000.00	210803
45	Тээврийн хэрэгслийн татвар	63,320.00	78,800.00	210804
46	Тээврийн хэрэгслийн оношилгоо	16,500.00	36,500.00	210805
47	Газрын төлбөр	-	150,000.00	210807
48	Бараа үйлчилгээний бусад зардал	41,950,202.20	42,128,093.29	2109
49	Бараа үйлчилгээний бусад зардал	6,190,230.00	4,869,690.00	210901
50	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,759,972.20	37,258,403.29	210903
51	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	323,732.00	8,748,356.00	213
52	Засгийн газрын урсгал шилжүүлэг	123,732.00	-	2131
53	Засгийн газрын дотоод шилжүүлэг	123,732.00	-	213101
54	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	7,826,200.00	2132
55	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	200,000.00	7,826,200.00	213209
56	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	922,156.00	2134
57	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	922,156.00	213403
58	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(49,917,879.48)	1,123,838,969.72	3
59	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	6,351,567.24	-	5
60	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,351,567.24	-	225001
61	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(6,351,567.24)	-	6
62	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(56,269,446.72)	1,123,838,969.72	7

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хугацаа: 17.12.31

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	ДАНС
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	276,926,600.00	319,440,100.00	1
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,000.00	1,208,100.00	12
2	Нийтлэг татварын бус орлого	50,000.00	1,208,100.00	120
3	Төсөвт байгууллагын өөрийн орлого	50,000.00	1,208,100.00	120004
3	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	-	1200041
4	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,208,100.00	1200042
4	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	276,876,600.00	318,232,000.00	13
5	Улсын төвлөрсөн төсвөөс	28,079,100.00	318,232,000.00	1310
5	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	28,079,100.00	318,232,000.00	131001
6	Төсвийн захирагчдаас	248,797,500.00	-	1330
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	248,797,500.00	-	133001
7	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	276,926,600.00	319,440,100.00	2
7	УРСГАЛ ЗАРДАЛ	276,926,600.00	319,440,100.00	21
8	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	276,602,868.00	310,691,744.00	210
8	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	185,157,900.00	191,229,377.00	2101
9	Үндсэн цалин	178,246,500.00	177,386,177.00	210101
9	Үр дүнгийн урамшуулал	6,911,400.00	13,843,200.00	210104
10	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	20,274,189.00	21,028,000.00	2102
10	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,274,189.00	21,028,000.00	210201
11	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	24,119,800.00	48,014,761.00	2103
11	Гэрэл цахилгааны зардал	4,632,976.00	4,081,868.00	210301
12	Түлш, халаалтын зардал	14,596,218.00	41,636,130.00	210302
12	Цэвэр, бохир усны зардал	4,890,606.00	2,296,763.00	210303
13	Хангамж, бараа материалын зардал	13,148,255.00	12,805,629.00	2104
13	Бичиг хэрэг	1,383,000.00	1,884,600.00	210401
14	Тээвэр, шатахуун	9,921,000.00	9,409,104.00	210402
14	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	862,705.00	606,405.00	210403
15	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	981,550.00	905,520.00	210405
15	Нормативт зардал	24,035,999.00	26,554,697.00	2105
16	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,072,699.00	19,382,111.00	210501
16	Хоол, хүнс	5,601,700.00	5,250,586.00	210502
17	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,361,600.00	1,922,000.00	210503
17	Эд хогшил, урсгал засварын зардал	2,294,500.00	2,541,240.00	2106
18	Багаж техник хэрэгсэл	1,329,200.00	1,469,940.00	210601
18	Урсгал засвар	965,300.00	1,071,300.00	210604
19	Томилолт, зочны зардал	820,500.00	1,013,250.00	2107

Говьсүмбэр аймгийн “Шивээговь сумын Эрүүл мэндийн төв”-ийн 2017 оны санхүүгийн тайлан

19	Дотоод албан томилолт	820,500.00	1,013,250.00	210701
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	561,495.00	1,990,300.00	2108
20	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,440,000.00	210802
21	Даатгалын үйлчилгээ	81,675.00	285,000.00	210803
21	Тээврийн хэрэгслийн татвар	63,320.00	78,800.00	210804
22	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	36,500.00	210805
22	Газрын төлбөр	-	150,000.00	210807
23	Бараа үйлчилгээний бусад зардал	6,190,230.00	5,514,490.00	2109
23	Бараа үйлчилгээний бусад зардал	6,190,230.00	5,514,490.00	210901
24	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	323,732.00	8,748,356.00	213
24	Засгийн газрын урсгал шилжүүлэг	123,732.00	-	2131
25	Засгийн газрын дотоод шилжүүлэг	123,732.00	-	213101
25	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	7,826,200.00	2132
26	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	200,000.00	7,826,200.00	213209
26	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	922,156.00	2134
27	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	922,156.00	213403
27	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-	
28	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-	
28	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-	8
29	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	9
29	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	10

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хугацаа: 17.12.31

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	КО Д
0	ДАНС	511	51300	51210+51220		
1	2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	246102032.00	181024092.00	91811987.66	518938111.66	C01
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					C02
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	246102032.00	181024092.00	91811987.66	518938111.66	C03
4	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн					C04
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз					C05
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз					C06
7	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		0	-17343157.39	-17343157.39	C07
8	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	0		C08
9	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	246102032.00	180998994.33	28019229.22	455120255.55	D01
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					D02
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	246102032.00	180998994.33	28019229.22	455120255.55	D03
12	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0				D04
13	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0				D05
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0				D06
15	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		0	1123838969.72	1123838969.72	D08
16	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	246102032.00	180998994.33	1151858198.94	1578959225.27	D09

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2017 он 12 сар 31 өдөр

/Төгрөг

	ЗАРДЛЫН ЗҮЙЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ
110000	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			
	НИЙТ ЗАРЛАГА	318,232,000	317,309,844	922,156
	1.1 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	191,229,400	191,229,377	23
210101	Үндсэн цалин	177,386,200	177,386,177	23
210102	Нэмэгдэл			
210103	Унаа хоолны Хөнгөлөлт			-
210104	Урамшуулал	13,843,200	13,843,200	-
210105	Гэрээт ажлын хөлс			-
	1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,028,000	21,028,000	-
	1.3 Бараа үйлчилгээний болон бусад зардал	105,974,600	105,052,467	922,133
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,922,600	48,014,761	907,839
210301	Гэрэл, цахилгаан	5,755,300	4,081,868	1,673,432
210302	Түлш, халаалт	36,470,500	41,636,130	(5,165,630)
210303	Цэвэр, бохир ус	6,696,800	2,296,763	4,400,037
210304	Байрны түрээс			-
	Хангамж, бараа материалын зардал	12,805,800	12,805,629	171
210401	Бичиг хэрэг	802,200	1,884,600	(1,082,400)
210402	Тээвэр, шатахуун	9,781,600	9,409,104	372,496
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	986,500	606,405	380,095
210404	Ном, хэвлэл	-		-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,235,500	905,520	329,980
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	-
	Нормативт зардал	26,185,200	26,185,197	3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,295,500	19,012,611	(717,111)

Говьсүмбэр аймгийн “Шивээговь сумын Эрүүл мэндийн төв”-ийн 2017 оны санхүүгийн тайлан

210502	Хоол, хүнс	5,940,000	5,250,586	689,414
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,949,700	1,922,000	27,700
	Эд хогшил, урсгал засварын зардал	2,541,300	2,541,240	60
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,470,000	1,469,940	60
210604	Урсгал засвар	1,071,300	1,071,300	-
	Томилолт зочны зардал	1,016,100	1,013,250	2,850
210701	Гадаад албан томилолт			-
210702	Дотоод албан томилолт	1,016,100	1,013,250	2,850
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,001,500	1,990,300	11,200
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000	1,440,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	285,000	285,000	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000	78,800	11,200
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	36,500	36,500	-
210807	Газрын төлбөр	150,000	150,000	-
	Бараа үйлчилгээний бусад зардал	5,514,500	5,514,490	10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,514,500	5,514,490	10
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх			-
	Бусад урсгал шилжүүлэг	6,987,600	6,987,600	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	6,987,600	6,987,600	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		922,156	(922,156)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	318,232,000	317,309,844	922,156
	Улсын төсвөөс санхүүжих	318,232,000	317,309,844	922,156
310001	Улсын төсвөөс санхүүжих	318,232,000	317,309,844	922,156

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 05 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг мэдэгдье.

Асуудал 1: Нийгмийн даатгалын тайлагналын ТАЛААР

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №01

Илрүүлэлт

Нийгмийн даатгалын тайланд хоёр ажилтны цалинг 2,051.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Дарга
Нягтлан

П.Ганчимэг
О.Дөлгөөн

Зөвлөмж

Нийгмийн даатгалын тайланг тухай бүр үнэн зөв гаргаж, дутуу тайлагнасан цалин НДХ-т нөхөн тайлан гаргаж залруулах

Эрсдэл

Нотлох баримт хангалтгүй байх нь төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Дарга
Нягтлан

П.Ганчимэг
О.Дөлгөөн

Асуудал 2: Орлогын ТАЛААР

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №02

Илрүүлэлт

Төлбөрт үйлчилгээний орлого 1,208.1 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч, эм, эмнэлгийн багаж хэрэгсэл болон нэг удаагийн тэтгэмж урамшуулалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.5, 47.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Дарга П.Ганчимэг
Нягтлан О.Дөлгөөн

Эрсдэл

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах

Зөвлөмж

Төлбөрт үйлчилгээний орлогыг төлөвлөж, төсөвт батлуулан зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Дарга П.Ганчимэг
Нягтлан О.Дөлгөөн